



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/571

Эрдэнэт

Өсвөрийн морин хуурчдын олон улсын уралдааны
зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.1.5/а/, 29.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 /2/ дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрдэнэтийн морин хуурын төв" төрийн бус байгууллагаас санаачлан Орхон аймагт 2018 оны 11 дүгээр сарын 12,13,14-ний өдрүүдэд зохион байгуулах "ӨСВӨРИЙН МОРИН ХУУРЧДЫН ОЛОН УЛСЫН УРАЛДААН"-ныг зохион байгуулах зардалд 5780000 /таван сая долоон зуун наян мянган/төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Уралдаан зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Нийт зардал болох 5780000 /таван сая долоон зуун наян мянган/ төгрөгийг "Улсын чанартай спорт, соёл, урлагийн арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулах" арга хэмжээний зардлаас гаргахыг гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын
19 ны өдрийн 591 дугаар захирамжийн хавсралт

“ӨСВӨРИЙН МОРИН ХУУРЧДЫН ОЛОН УЛСЫН
УРАЛДААН”-НЫ ТӨСӨВ

№	Зарцуулах төсөв	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ/төгрөгөөр/	Бүгд үнэ /төгрөгөөр/
1.	Засаг даргын нэрэмжит шагнал	1	250000	250000
2.	Гран-При шагнал	1	250000	250000
3.	Шилдэг багшийн шагнал	1	250000	250000
4.	Шагнал урамшуулал	2	370000	740000
5.	Уралдааны цом	3	70000	210000
6.	Концертмейстр	2	500000	1000000
7.	Шүүгчийн урамшуулал	5	25000	1250000
8.	ОХУ, БНХАУ-аас оролцогчдын байрны зардал	15	55000	825000
9.	Алт, мөнгө, хүрэл медаль	6	25000	150000
10.	Уралдааны хөтөлбөр танилцуулгын самбар	3	35000	105000
11.	Гала тоглолтын заллага	250	3000	750000
Нийт дүн				5.780.000